

1

ХОГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ЗАСГИЙН ГАЗРУУД ХЭТЭРХИЙ ЖИЖИГ БАЙНА УУ?

С.Баттулга

1. Удиртгал

Засгийн газар тухайн улсын хөгжлийн нэгэн чухал оролцогч бөгөөд түүний хэмжээ ба үйл ажиллагаа нь эдийн засгийн гүйцэтгэлд нөлөөлдөг хүчин зүйл гэдэг нь эргэлзээнгүй хэрэг билээ. Тиймээс засгийн газрын мөн чанарыг сайтар судалж түүний үйл ажиллагаа буюу үйл хөдлөлийн үр дагаврыг ойлгох нь чухал юм.

Гэвч түүний мөн чанарыг ойлгохын тулд зүгээр л засгийн газрын секторын хэдэн статистик дээр төвлөрөх нь утгагүй хэрэг болно. Энэ нь уг асуудлыг авч үзэхийн тулд тодорхой хандлага баримтлах ёстой гэдгийг хэлж өгч байгаа юм. Тиймээс энэ өгүүллэг шинэ институцийн экономиксийн хүрээнд бичигдсэн ба Харвардын их сургуулийн профессор Алберто Алесина (1998)-ийн "Хэтэрхий том ба хэтэрхий жижиг засгийн газрууд" гэсэн ажил болон орчин үеийн төрийн мөн чанартай холбоотой, төрийн үүрэг ба үр ашгийн талаар бичсэн хамгийн нөлөө бүхий ажлуудын нэг Дэлхийн Хөгжлийн Илтгэл (ДХИ) 1997 дээр тус тус суурилсан болно.

Өгүүллэгийн эхний хэсэгт засгийн газар ерөнхийдөө юу хийх учиртай талаар товч тайлбарласан. Дараагийн хэсэг Алесинагийн ажлыг хураангуйлсан бол удаах хэсэгт хогжиж буй орнуудын засгийн газрууд хэтэрхий жижиг байна уу? гэсэн асуултыг шүүмжлэлтэйгээр авч үзлээ. Төгсгөлийн хэсэг нь дүгнэлт болно.

2. Засгийн газар юу хийх ёстой вэ?

Аткинсон ба Стиглиц (1980: 4-5) нарын бичсэнээр "төр¹ ... суурь үүргүүдийг гүйцэтгэх ба тэр дундаа түүний эхний үүрэг бол "эдийн засгийн тоглоомын дүрэм"-ийг тогтоож хэрэгжилтийг хангах явдал юм. Эдгээр дүрмүүд гэрээ, дампуурах нөхцлүүд, болон өмчийн эрх ба өр төлбөрийг тодорхойлсон хуулиудын хэрэгжилтийг хангах зэргийг агуулдаг байна".

Засгийн газрын үндсэн үүргүүдийг дараах байдлаар нэгтгэж болно (Лоосон 2006: үзүүлэн 5):

- Шаардлагатай хүмүүний, хуулийн болон биет дэд бүтцийг бий болгох замаар эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих (зах зээлийн сул талыг залруулах)
- Орлого ба боломжийг дахин хуваарилах замаар нийгмийн хэм хэмжээ болон суурь амьжиргааны түвшинг хадгалж байх (дахин хуваарилалт)
- Нийгэм болон эдийн засгийн эрдлийн эсрэг даатгалаар хангах (даатгал)

Илүү өргөн утгаараа 1997 оны ДХИ-д дурдснаар бол засгийн газар дараах зүйлсийг хийх учиртай ажээ (Волтерсийн нэгтгэсэнээр 2006: 6-8):

- ✓ Хуулийн суурийг бий болгох: зөв хуультай болж тэдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах
- ✓ Гажуудал үүсгэхгүй бодлогын орчинг бий болгох: бодлого урьдчилан таамаглахуйц, аливаа шийдвэр гаргалтанд харгалзаж болохоор байх бодлогын орчинг бий болгож гажуудал бүхий орчинг үүсгэх болдлогуудыг хэрэгжүүлэхгүй байх
- ✓ Нийгмийн суурь үйлчилгээ болон дэд бүтцэд хөрөнгө оруулах
- ✓ Эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах
- ✓ Байгаль орчинг хамгаалах

Оролцооны хэр хэмжээнээс нь хамааруулан төрийн үүргийг тодорхойлсон доорх хүснэгтээс засгийн газар юу хийх учиртай нь илүү тодорхой болно.

Хүснэгт 2. 1 Төрийн үүргүүд

Зах зээлийн сул талыг засах	Тэгш байдлыг сайжруулах
Цэвэр нийгмийн барааг хангах нь: Батлан хамаагаалах Хууль ба дэг журам Өмчийн эрх Макро эдийн засгийн удирлага Нийгмийн эрүүл мэнд	Ядуусыг хамгаалах нь: Ядуурлын эсрэг хөтөлбөрүүд Гамшгийн үеийн тусламж

¹ Өгүүллэгийн туршид засгийн газар ба төр гэсэн ойлголтууд ижил утга илэрхийлдгээс солигдон хэрэглэгдэх болно. ДХИ 1997-ын хайрцаг 1.1-ийг үз.

Дунд зэргийн оролцоо	Дам нолоог шийдэх нь: Суурь боловсрол Байгаль орчны хамгаалал	Монополийг зохицуулах нь: Эрчим хүч, ус хангамж Монополийн эсрэг бодлого	Тэгш бус мэдээллийг даван туулах нь: Даатгал (эрүүл мэнд, амь нас, тэтгэвэр) Санхүүгийн зохицуулалт Хэрэглэгчийг хамгаалах	Нийгмийн даатгал: Дахин хуваарилалтын сан Өрхий тэтгэмж Ажилгүйдлийн даатгал
	Идэвхтэй төр	Хувийн үйл ажиллагааг зохицуулах нь: Зах зээлийг хөгжүүлэх Кластерийн санаачлага		Дахин хуваарилалт: Хөрөнгийн дахин хуваарилалт

Эх сурвалж: ДХИ 1997, Хүснэгт 1.1, Хуудас. 27

Засгийн газар юу хийх учиртай талаар товч авч үзсний дараа гол асуудалдаа эргэн орё. Энэ нь эргэлзээнгүй, хөгжиж буй орнуудын засгийн газрууд хэт “жигжиг” байна гэсэн Харвардын их сургуулийн профессор Алберто Алесинагийн ажлыг авч үзснээр эхлэх болно.

3. Алесина юу гэв?

Ажлын эхний хэсэгтээ Алесина (1998: 3) ‘Ихэнх аж үйлдвэржсэн орнуудад засгийн газрууд нь хэтэрхий ихийг хийх гэж оролдож байна. Тэдний нийгмийн даатгалаар хангах гэсэн хэтэрсэн хүчин чармайлт нь бүтээмжийг бууруулж, үнэн хэрэгтээ эдгээр өргөн хүрээний шилжүүлгийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд шаардлагатай татварын нэмэгдэл ачаалал нь өсөлтийг бууруулж ажилгүйдлийг ихэсгэлээ. Нөгөө талд, бага орлоготой орнуудын олон засгийн газрууд хангалттай зүйл хийхгүй байна. Тэд дэд бүтцээр хангах буюу тэгш бус байдлыг бууруулахын тулд нэмэртэй юу ч хийдэггүй. Үгүй бол тэдний хийж байгаа нь үр ашиггүй бөгөөд авилгад автсан байдаг. Эдгээр орнуудад засгийн газрууд нь ихэнхдээ хөгжилд шаардлагатай хамгийн суурь нийгмийн барааг ч нийлүүлж дэд бүтцээр хангаж чадахгүй байна’ гэжээ.

Алесина засгийн газрын зарлагын бүрэлдэхүүн хэсгүүдийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, нийт орлого, үндсэн зарлага, болон засгийн газрын нийт зарлагын ДНБ-д эзлэх хувиудын өөрчлөлт зэрэг үзүүлэлтүүдээр Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын орнуудын засгийн газрууд хэт том, хөгжиж буй орнуудын засгийн газрууд хэт жигжиг байгааг харуулжээ. Гэвч түүний ажлын гол санаа хөгжиж байгаа олон орнуудын засгийн газрын хэмжээ гэхээсээ зарлагын чанар муу байгааг онцолсон. Түүнийхээр (мөн ажил. 11-12) ‘ядуусын төлөө гэсэн зарлагууд нь хүртэл ядуурал, орлогын тэгш бус байдлыг бууруулахаар юу ч хийхгүй байна...’. Алесина уг чанар муутай зарцуулалтын гол шалгааныг зорилтот хэсэгтээ чиглээгүй зарлага,

хэт их хээл хахууль ба удирдлагын тогтолцооны үр ашиггүй байдал хэмээн тайлбарлажээ.

Түүний ажлын оор нэг чухал санаа бол хөгжиж буй орнуудад нүүрлээд байгаа чөтгөрийн цагираг юм. Түүний нотолж байгаагаар хөгжиж буй олон орнуудын эдийн засгийн үлэмжхэн хэсэг хар буюу үгүй ядаж саарал хэсэгт хамаарч байна. Энэ нь албан секторын үр ашигтай холбоотой. Үнэн хэрэгтээ, ‘олон бизнес ба хувь хүмүүс эдийн засгийн албан секторт бэлэн байдаг төрийн дэд бүтцийг хэрэглэх чадахгүй болох байсан ч хамаагүй татвар болон зохицуулалтаас зайлсхийхийг илүүд үзэж байна. Төрийн сектор хэдий чинээ үр ашиггүй болно, албан секторын үр өгөөжийг төдий чинээ бууруулж албан бус секторт илүү сэтгэл тагам боломжууд гарч ирнэ’ (мөн ажил. 19). Тэрээр үргэлжлүүлэн (мөн тэнд.) ‘Албан бус сектор хэдий чинээ том болно засгийн газарт тэр хэмжээгээр татвар хураахад хэцүү болно. Татварын орлого бага болохоор засгийн газар зарлагаа бага байлгахад хүрнэ. Ихэнхдээ санхүүжүүлэхээ больсон зарлагын хөтөлбөрүүд хамгийн үр ашиггүй хөтөлбөрүүд байдаггүй. Харин дэмжих дуу хоолой, ар тал байхгүй хөтөлбөрүүд тасардаг. Тиймээс татварын бага орлого нийгмийн бараа болон дэд бүтцийн үр ашгийг бууруулдаг’ гэжээ. Энэ үйл явц яриангүй үр ашиггүй засгийн газрыг бий болгоно. Энэ нь хөгжиж буй орнуудад тулгараад байгаа бага орлогын чөтгөрийн цагираг юм. ‘Бага орлоготой байснаар үр ашиггүй засгийн газар бий болж эдийн засаг улам илүүтэйгээр албан бус болох сэдлийг төрүүлэн татварын орлогыг улам ихээр бууруулахад хүргэж байна’ (мөн тэнд).

Энэ хэсгийг Алесинагийн ажлын гол дүгнэлтээр төгсгөе. ‘... Жигжиг засгийн газруудтай хөгжиж буй орнуудад орлогоо нэмэгдүүлэх нь төвөгтэй байдаг’ (мөн ажил. 23). ‘[Хөгжиж буй орнуудын хувьд] нийгмийн зорилтуудад хүрэхийн тулд засгийн газар зорилтот хэсгүүдэд чиглэж чадаагүй халамжийн хөтөлбөртэй, дэд бүтэцгүй, татвараас зайлсхийдэг эдийн засгийг харьцангуй жигжиг боловч үр ашигтай нийгмийн халамжийн хөтөлбөртэй, татвар төлдөг албан эдийн засаг болгох хэрэгтэй. Гол хүндрэл нь гэвэл эдгээр шинэчлэлүүд авилгыг бууруулж удирдлагын үр ашгийг дээшлүүлэхгүйгээр амжилттай болохгүйд байгаа юм’ (мөн тэнд).

4. Хөгжиж буй орнуудын засгийн газрууд үнэхээр “хэтэрхий” жигжиг үү?

Алесинагийн нотолгоог авч үзсний дараа дээрх асуултыг асуух нь үнэхээр зүйн хэрэг.

Уг асуултанд хариулахын тулд сүүлийн үеийн нохицлийг харуулсан засгийн газрын хэмжээний статистикийг авч үзэх хэрэгтэй.²

Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлт (ДХҮ)-үүдээс харахад хөгжиж буй орнуудын засгийн газрууд өнөө хэр жигжиг байгаа ч хөгжингүй орнуудын засгийн газруудаас хурдан өсч байна. Үүнийг дараах хүснэгтүүдээс харж болно:

² Учир нь Алесинагийн ажил хуучирсан байж мэдэх тул нохицол байдал өөрчлөгдсөн эсэхийг авч үзэхийн тулд сүүлийн үеийн статистикийг авч үзэх хэрэгтэй. Алесинагийн ажлын эхний хувилбар 1998 онд буюу 10 гаран жилийн өмнө гарсан билээ.

Хүснэгт 4.1 Засгийн газрын эцсийн хэрэглээний зарлагын ДНБ-д эзлэх хувь

	1990	2004	2008
Дэлхий	17	17	..
Бага орлоготой орнууд	13	11	10
Дунд орлоготой орнууд	13	14	14
-Дундын доод	14	13	13
-Дундын дээд	13	14	15
Бага ба дунд орлоготой орнууд	13	13	14
Өндөр орлоготой орнууд	18	18	..
Евро бүс	20	20	20

Эх сурвалж: ДХҮ 2009

Хүснэгт 4.2 Засгийн газрын эцсийн хэрэглээний зарлагын жилийн өсөлт

	1990	2000	2004	2008
Дэлхий	3	3	2	..
Бага орлоготой орнууд	..	8	5	..
Дунд орлоготой орнууд	0	4	4	8
-Дундын доод	4	7	5	10
-Дундын дээд	-2	2	3	5
Бага ба дунд орлоготой орнууд	0	4	4	8
Өндөр орлоготой орнууд	3	3	2	..
Евро бүс	3	2	2	2

Эх сурвалж: ДХҮ 2009

Гэвч үнэн хэрэгтээ Алесинагийн ажил хөгжиж буй орнуудын засгийн газрууд өөрсдийн тохиромжтой буюу үр ашигтай хэмжээний хувьд хэт жижиг байгаа гэдгээс биш хөгжингүй орнуудын засгийн газруудтай харьцуулаагүй юм. Үүнтэй төстэй дүгнэлтийг хөгжингүй орнуудын засгийн газруудын хувьд ч бас хийж болно. Учир нь тэдгээр орнуудын засгийн газрууд өөрсдийн орны өсөлтийг бууруулж ажилгүйдлийг ихэсгэхүйц хэт том байгаа юм. Гэлээ гэхдээ хөгжингүй орнуудын эдийн засгийн гүйцэтгэл сайн байдгаас хөгжиж буй орнуудын гүйцэтгэлийг ихэнхдээ хөгжингүй орнуудын гүйцэтгэлтэй харьцуулах билээ.

Алесинагийн гол санааг эргэн санахад тэр хөгжиж буй орнуудын засгийн газрууд “хэт” жижиг байгаа бөгөөд зорилгот хэсэгт чиглэж чадаагүй төрийн зардал, газар авсан авилга, удирдлагын үр ашиггүй байдал, том албан бус сектор, татварын бага орлого ба засгийн газрын чанар муутай зарлага зэрэг эргээд үр ашиггүй төрийн секторыг бий болгодог хүчин зүйлээс үүдэлтэй үр ашиггүй

төрийн сектороос болоод хийвэл зохих ажлаа ч хийж чадахгүй байгаа хэмээн нотолсон. Хэдийгээр энэ нь хөгжиж буй орнуудад тулгараад байгаа чөтгөрийн цагираг боловч энэ өгүүллэгт уг цагирагийн эхлэлийг үр ашиггүй төрийн сектор буюу өөрөөр хэлбэл зорилгот хэсэгтээ чиглээгүй төрийн зарлага, газар авсан авилга, ба удирдлагын үр ашиггүй байдал гэж харуулахыг зорьж байна. Эдгээр асуудлууд болон тэдгээрийн үр дагавруудыг одоо нэг бүрчлэн дэлгэрэнгүй авч үзье.

Зорилгот хэсэгт чиглээгүй төрийн зарлага, газар авсан авилга ба удирдлагын үр ашиг

Эхний асуудал болох зорилгот хэсэгт чиглээгүй төрийн зарлагыг Алесинагийн ажилд хангалттай хэлэлцсэн тул орхиод бусад хоёр асуудлыг авч үзье.

ДХИ 1997-д дурдсанаар (1) "... олон орнуудад ... засгийн газрууд мөрөөдлийн толоогоор автаад байна. Хувийн хоронго оруулагчид төрийн бодлого болон удирдагчдын найвартай байдалд итгэх итгэл алдсан. Хүчирхэг удирдагчид өөрсдийн зоргоор авирлаж авилга газар аван хөгжил саатаж ядуурал ихэсч байна". Харамсалтай нь, ийм байдалд байгаа ихэнх орнууд нь хөгжиж байгаа орнууд байна.

1997оны ДХИ-г бичих явцад 69 оронд хийгдсэн орон нутгийн аж ахуй эрхлэгчдийн судалгаанаас үзэхэд "олон засгийн газрууд өөрсдийн үндсэн үүргээ сул гүйцэтгэж байна. Тэд хууль дүрмийг сахиулж өмчийг хамгаалж чадахгүй байгаагийн хажуугаар урьдчилан тааварлахуйц бодлогыг хэрэгжүүлэхгүй байгаа ажээ. Хоронго оруулагчид ийм төрийг итгэл даахуйц гэж үзэхгүй байна" (мөн ажил. 5). Уг судалгаагаар бүх хөгжиж буй бүсүүдийн институцийн тогтолцооны найдвартай байдлын ерөнхий хэмжүүр өндөр орлоготой ЭЗХАХБ-ын орнуудын үзүүлэлтээс наад зах нь 20 хувиар доогуур байв. Энэ нь яриангүй аж ахуй эрхлэгчдийг албан бус эдийн засаг уруу түлхэж байгаа хүчин зүйл юм. Түүнээс гадна, асуулганд оролцсон хөгжиж буй орнуудын оролцогсад өндөр орлоготой ЭЗХАХБ-ын орнуудын оролцогсодтой харьцуулахад хууль ба бодлогын гэнэтийн оорчлолт, тогтвортой төр, өмчийн аюулгүй байдал, найдвартай шүүх ба авилга зэрэг төрийг итгэл даахуйц болгодог институцуудын талаар ямагт илүүтэй сэтгэл ханамжгүй байдгаа илэрхийлсэн байна.

Судалгаагаар авилга хоронго оруулагчдын хувьд чухал хийгээд өргөн тархсан асуудал болоод байгаа нь илэрсэн. Ерөнхийдөө, аж ахуй эрхлэгчдийн дөчөөс илүү хувь нь ажил хэргээ бүтээхийн тулд авилга өгч байсан хэмээн хариулсан байна. Аж үйлдвэржсэн орнуудад энэ үзүүлэлт 15 хувьтай байсан бол Азид 30 хувь, Тусгаар Орнуудын Хамтын Нөхөрлөл (ТОХН)-ийн орнуудад 60 хувь байжээ. Бүх хөгжиж буй бүсийг авч үзвэл уг үзүүлэлт өндөр орлоготой ЭЗХАХБ-ын орнуудтай харьцуулахад дор хаяж 3 дахин их байна.

Үнэн дүр төрх дараах хүснэгтээс илүү тодорхой болно:

Хүснэгт 4.3 Аж ахуй эрхлэхэд учирч буй бэрхшээлүүдийн эрэмбэлэл*

Бэрхшээлүүд	Сахарын Африк	Латин Америк ба Кариб	Зүүн Өмнөд Ази	Ойрхи Дорнод ба Хойд Африк	ТОНХ	Төв ба Зүүн Европ	Өндөр орлоготой ЭЗХАХБН
Өмчийн эрх							
-авилга	1	1	3	2	3	3	5
-гэмт хэрэг ба хулгай	5	3	8	8	4	6	6
-зохицуулалт	8	8	7	7	8	8	4
Бодлого							
-татвар	2	5	2	3	1	1	1
-санхүү	6	4	5	4	5	2	2
-инфляц	4	7	4	6	6	4	8
-бодлогын тогтворгүй байдал	7	6	6	5	2	7	7
Улсын хөрөнгө оруулалт							
-сул дэд бүтэц	3	2	1	1	7	5	3

Тэмдэглэл: хамгийн муу=1 Эх сурвалж: ДХИ 1997, Хайрцаг 3.1

Дээрх хүснэгтээс харахад авилга, татварын бодлого болон улсын хөрөнгө оруулалтын асуудлууд бизнес эрхлэхэд хамгийн их бэрхшээл үүсгэдэг байна. Татварын бодлого илүүтэй хөгжингүй орнуудын бизнес эрхлэгчдийн асуудал байдаг бол Латин Америк болон Сахарын Африкт авилга аж ахуй эрхлэхэд хамгийн их бэрхшээл болдог нь харагдав.

Алесинагийн тайлбарласны дагуу үр ашиггүй төрийн сектор албан бус секторыг томроход хүргэж татварын орлогыг бууруулдаг. Одоо эдгээр асуудлуудыг авч үзье.

Албан бус эдийн засаг

Шнейдерийн нотолж байгаагаар (2002: 5-15) 1999-2000 онд Африкт албан бус эдийн засаг дундажаар ДНБ-ий 42 хувьтай тэнцүү байжээ. Зимбабвэ, Танзани, ба Нигериагийн албан бус эдийн засгууд харгалзан 59.4, 58.3 ба 57.9 хувь байснаараа хамгийн өндөр байв.

Азийн орнуудын хувьд мөн хугацаанд Тайланд хамгийн том албан бус эдийн засагтай байсан. ДНБ-д эзлэх хувь нь 52.6 байсан бол дараа нь 44.6 хувьтай Шриланка, удаад нь Филиппин 43.4 хувьтайгаар оржээ. Дундаж

орнуудад Энэтхэг, Израйль, Тайван ба Хятад орж байсан бол хамгийн бага албан бус эдийн засагтай орнууд нь 13.1 хувьтай Сингапур, 11.3 хувьтай Япон байсан. Дундажаар Азийн орнуудын албан бус эдийн засаг ДНБ-ий 26 хувьтай тэнцэж байсан байна.

Өмнөд болон Латин Америкийн 18 орнуудын хувьд албан бус эдийн засаг 41 хувьтай байв. Хамгийн том албан бус эдийн засаг Боливид байсан бол Панама болон Перу 64.1 ба 59.9 хувиар удаалжээ. Хамгийн бага албан бус эдийн засаг Чили ба Аргентинд байсан.

23 шилжилтийн эдийн засгийг авч үзэхэд албан бус эдийн засаг ДНБ-ий 38 хувьтай тэнцэж байсан. Хамгийн том албан бус эдийн засаг Гүржид байсан бол дараа нь Азербайжан, Украин орсон байв. Дундаж хэмжээтэй албан бус эдийн засгууд Болгар, Румынд байсан бол хамгийн бага албан бус эдийн засагтай орнууд Унгар, Чех, Словак байжээ.

Баруун Европын ЭЗХАХБ-ын 16 орны хувьд Грек болон Итали хамгийн том албан бус эдийн засгуудтай орон байсан бол Дани, Германы албан бус эдийн засаг дундаж хэмжээтэй, Австри болон Швейцарийн албан бус эдийн засгууд ДНБ-ий харгалзан 10.2 ба 8.8 хувь гэж тооцогдсон байсан. Эдгээр орнуудын албан бус эдийн засгийн дундаж хэмжээ 18 хувь байв.

Австрали, Канад, Шинэ Зеланд ба АНУ гэсэн 4 ЭЗХАХБ-ын орнуудын хувьд Канад хамгийн том албан бус эдийн засагтай байсан бол Австрали, Шинэ Зеланд удаалж АНУ ДНБ-ий 8.8 хувьтай тэнцэх хамгийн бага албан бус эдийн засагтай орон байсан. Дундажаар эдгээр 4 орны албан бус эдийн засаг ДНБ-ий 13.5 хувьтай тэнцүү байжээ.

1989-1990 онд ЭЗХАХБ-ын 21 орнуудын хувьд албан бус эдийн засгийн хэмжээ 13.2 хувь байсан бол 2001-2002 онд 16.7 хувь болон өсчээ.

Омнох бүх тайлбаруудыг доорхи хүснэгтээр ерөнхийлөн харууллаа.

Хүснэгт 4.4 Улсуудын албан бус эдийн засгийн дундаж хэмжээ, 1999-2000

Улс	Албан бус эдийн засгийн дундаж хэмжээ, албан ёсны ДНБ-ий хувиар	Орнуудын тоо
Хөгжиж байгаа орнууд:		
Африк	42	23
Төв ба Өмнөд Африк	41	18
Ази*	29	26

Шилжилтийн орнууд	35	23
Баруун Европын ЭЗХАХБ-ын орнууд	18	16
Хойд Америк ба Номхон далайн ЭЗХАХБ-ын орнууд	13.5	4

*Энд бүх орнууд нь хөгжиж байгаа орнууд биш. Япон, Сингапур болон Хонгконг зэрэг улсууд орсон. Эх сурвалж: Шнейдер (2002), Хүснэгт 11. *Татварын орлого*

Дэлхийн банкны судалгаагаар засгийн газрын татварын орлого хураалт ДНБ-д дараах хувийг эзэлж байна:

Хүснэгт 4.5 Татварын орлого, ДНБ-ий хувиар

	2000	2004	2006
Дэлхий	15.7	14.5	16
Бага орлоготой орнууд	10.0	10.5	..
Дунд орлоготой орнууд	12.3	12.4	14
-Дундын доод	9.6	10.1	11
-Дундын дээд	18
Бага ба дунд орлоготой орнууд	11.9	12.0	14
Өндөр орлоготой орнууд	16.5	14.6	17
Евро бүс	19.2	17.9	19

Эх сурвалж: ДХУ 2009

Бэлэн байгаа хамгийн сүүлийн үеийн тооноос үзэхэд бага болон дундаж орлоготой хөгжиж буй орнуудын хувьд засгийн газрын цуглуулсан татварын орлого өндөр орлоготой болон Евро бүсийн орнуудтай харьцуулахад харьцангуй бага, ойролцоогоор 2-4 түүнээс илүү хувиар бага байгаа нь харагдаж байна.

Эдгээр бүх баримт, нотолгоонууд Алесинагийн бичснийг нотлоод зогсохгүй нэгэн маш чухал дүгнэлтэнд хүргэлээ. Хэдийгээр хөгжиж буй орнуудын засгийн газрууд хэмжээний хувьд жижиг байгаа ч үнэн хэрэгтээ тэд хийвэл зохих зүйлсээ хийж чадахгүй байгаа болон үйл ажиллагааных нь үр ашиг тэднийг "хэт" жижиг болгож байна. Энэ санаа засаглал болон шинэ институцийн экономиксийн чухал ойлголтууд уруу хөтөлж байгаа юм. Тиймээс энэ төрлийн асуудлыг уг хүрээнд авч үзэх нь хамгийн зохистой нь харагдаж байна.

Аз болоход 1997 оны Дэлхийн Хөгжлийн Илтгэл, Дэлхийн Банкны 12 дахь удаагийн илтгэлээр энэ асуудлыг гүнзгий авч үзсэн байдаг. Үнэндээ 1997

оны ДХИ нь төр, түүний мөн чанар, зах зээлтэй холбогдох холбоо хамаарлын тухай маш нөлөө бүхий эрс шинэ хандлагатай бүтээл юм. Тиймээс өгүүллэгийн дараагийн хэсэг уг илтгэл дээр суурилсан болно.

Хэдийгээр энэ өгүүллэгт хөгжиж буй орнуудын засгийн газрууд хөгжингүй орнуудын засгийн газруудтай харьцуулахад харьцангуй жижиг гэдгийг харуулж байгаа боловч өгүүллэгийн гол санаа нь эдгээр засгийн газруудын үйл ажиллагааны үр ашгийн тухай асуудал юм. Үнэн хэрэгтээ, хөгжиж буй орнуудын засгийн газрууд оорсдийн хүч болон хүлээн зөвшөөрөгдөх байдлаа баталгаажуулахаар үр ашигтай буюу зөвөөр ажиллаж чадахгүй байна. Энэ нөхцөл байдал үнэндээ хөгжиж буй орнуудын засгийн газрууд хэт жижиг гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Тиймээс тэдний хувьд оорсдийн хийвэл зохих зүйлсээ хязгаарлагдмал нийгмийн нооцийн ашиглалтын үр ашигт анхаарлаа хандуулангаа үр ашигтайгаар хийх нь маш чухал байна. Гэвч энэ нь эдгээр засгийн газруудад зайлшгүй шаардалгатай байгаа институцийн орчин болон тэдний чадавхийг сайжруулахгүйгээр боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хөгжиж буй орнуудын засгийн газруудад эдгээр орнуудад газар аваад байгаа засгийн газрын сул талыг даван туулах нь чухал байна. Энэ нь эргээд сайн засаглал болон шинэ институцийн экономиксийн ойлголтууд хөгжиж буй орнуудын засгийн газруудад үнэхээр чухал гэдгийг харуулж байна.

ДХИ 1997-д дурдснаар (3), "илүү чадавхитай төр илүү үр ашигтай байж чадна. Гэвч үр ашиг ба чадавхи хоёр ялгаатай. Төрийн чадавхи гэдэг нь хууль ба дүрэм, нийгмийн эрүүл мэнд болон суурь дэд бүтэц зэрэг хамтын үйлдлийг үр ашигтайгаар урамшуулж хэрэгжүүлэх чадварыг хэлнэ. Үр ашигтай байдал гэдэг нь уг чадавхийг эдгээр бараануудын нийгмийн эрэлтийг хангахад зориулсны үр дүн юм. Төр чадавхитай ч хэрэв уг чадавхийг нийгмийн эрх ашгийн төлөө зориулаагүй бол үр ашигтай биш байж болно".

Дүгнэлт

Уг өгүүллэг хөгжиж буй орнуудын засгийн газрууд хэт жижиг байгаа эсэхийг шүүмжлэлтэйгээр үнэлэхийг хичээлээ. Үүний тулд засгийн газрын хэмжээтэй холбоотой хэдэн статистикийг харьцуулахыг зориогүй бөгөөд засгийн газрын үйл ажиллагааны чанарт төвлөрөхийг зорьсон болно. Хэдийгээр хөгжиж буй орнуудын засгийн газрууд хөгжингүй орнуудын засгийн газруудтай харьцуулахад хэмжээгээрээ жижиг хэвээрээ байгаа боловч энэ нь гол асуудал биш юм. Хэрэв тэд нөөцөө үр ашигтай ашиглаж хийвэл зохих зүйлсээ үр ашигтайгаар хийвэл эдгээр засгийн газрууд тухайн улсын хөгжлийн үйл явцын чухал бөгөөд "том" оролцогч байж чадна. Үнэн хэрэгтээ хөгжиж буй орнуудын засгийн газрын сул тал болон муу хөгжсөн институцийн орчин тэдний хэт жижиг бөгөөд чадавхгүй засгийн газруудын жинхэнэ шалтгаан юм.

1997 оны ДХИ-д дурдсанчлан төрийн зарлага одоо аж үйлдвэржсэн орнуудын нийт орлогын бараг тал, хөгжингүй орнуудад дөрөвний нэгтэй тэнцэж байна. Гэвч төрийн энэхүү нэмэгдсэн оролцоо анхаарлыг тоон үзүүлэлтээс

чанарын үзүүлэлт үрүү, төрийн хэмжээ ба оролцооны цар хүрэнээс хүмүүсийн хэрэгцээг хэр үр ашигтайгаар хангаж байгаад илүүтэй чиглүүлж байна.

Зарим нэг нь 1997 оны ДХИ-ийн дүгнэлт, нотолгоонууд хуучирсан хэмээн маргаж болох ч хөгжиж буй орнуудын нөхцөл байдал үнэндээ 1997 оноос эрс сайнаар өөрчлөгдөх битгий хэл харин муудаж байж ч мэдэхээр байгааг сүүлийн үеийн олон улсын мэдээнүүдээс харж болно. Тиймээс уг илтгэлийн тайлбар ба нотолгоонууд өнөө хэр амьд, үнэмшилтэй төдийгүй үнэтэй бас санаж байхад чухал хэвээрээ байгаа.

Ашигласан ном зүй

- ☑ ABRAMS, B. A. (1999) 'The effect of government size on the unemployment rate', *Public Choice*, 99: 395–401.
- ☑ Alesina, A. (1998) 'Too Large and Too Small Governments', paper prepared for conference on economic policy and equity, Washington, D. C, USA, 8-9 June.
- ☑ Atkinson, A. B. & Stiglitz, J. E. (1980) *Lectures on Public Economics*, McGraw Hill, London.
- ☑ Gwartney, J., Lawson, R., & Holcombe, R. (1998) *THE SIZE AND FUNCTIONS OF GOVERNMENT AND ECONOMIC GROWTH*, Joint Economic Committee [Online], Available: <http://www.house.gov/jec/growth/function/function.pdf> [Accessed: 30 October 2006]
- ☑ LANDAU, D. L. (1985) 'Government expenditure and economic growth in the developed countries: 1952-76', *Public Choice*, 47: 459-477
- ☑ Lawson, D. (2006) *The Public Sector*, Economic Analysis of the Public Sector course unit handout, IDPM, University of Manchester, Manchester, 9 October.
- ☑ Schneider, F. (2002) *SIZE AND MEASUREMENT OF THE INFORMAL ECONOMY IN 110 COUNTRIES AROUND THE WORLD*, World Bank [Online], Available: http://rru.worldbank.org/Documents/PapersLinks/informal_economy.pdf [Accessed: 4 January 2007]
- ☑ Vedder, R. K. & Gallaway, L. E (1998) *GOVERNMENT SIZE AND ECONOMIC GROWTH*, Joint Economic Committee [Online], Available: <http://www.house.gov/jec/growth/govtsize/govtsize.pdf> [Accessed: 30 October 2006]
- ☑ Walters, B. (2006) *Lecture 8, Poverty, Inequality and Government Policy in Less Developed Countries* course unit handout, SSS, University of Manchester, Manchester, 29 November
- ☑ WB (2006) *World Development Indicators 2009*, World Bank [Online], Available: <http://databank.worldbank.org/ddp/home.do> [Accessed: 5 May 2010]
- ☑ WB (2006) *World Development Indicators 2006*, World Bank [Online], Available: <http://devdata.worldbank.org/wdi2006/contents/index2.htm> [Accessed: 5 January 2007]
- ☑ WB (1997) *World Development Report 1997: The State in a Changing World*, The World Bank, Oxford.